



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2020 оны 12 сарын 28 өдөр

Дугаар 71

Улаанбаатар хот

Ж.Солонгыг ажлаас чөлөөлөх тухай


Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Соёлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.1 дэх заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.3 дахь заалт, “Монгол кино нэгтгэл” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал Ж.Солонготой байгуулсан контрактын 5.3.11 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.“Монгол кино нэгтгэл” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирлын үүрэгт ажлаас Ж.Солонгыг 2021 оны 12 дугаар сарын 28-ны өдрөөр тасалбар болгон чөлөөлж, түүнтэй байгуулсан контрактыг цуцалсугай.

2. Тэтгэвэрт гарах болсонтой нь холбогдуулан Ж.Солонгод тэтгэмж олгох асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэхийг “Монгол кино нэгтгэл” төрийн өмчит үйлдвэрийн газрын Ерөнхий нягтлан бодогч Г.Төрбатад даалгасугай.

3.Ж.Солонготой холбогдох тооцоо хийж, тогтоолыг хэрэгжүүлж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

ДАРГА 
Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА  Ц.БАЯР-ЭРДЭНЭ

13201076